

**ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-13

1. Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан "Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох	3-13
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны
9 дүгээр сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний эрхийн дэд хорооны дарга С.Эрдэнэболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 23 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярбаатар, М.Нарантуяа-Нара;
Чөлөөтэй: П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Б.Энхбаяр.

Нэг.Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Оролцоо” төслийн зөвлөх Э.Эрдэнэхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт Л.Хурцбилэг байлцав.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 37 минут үргэлжилж, 12 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД
ХОРООНЫ ДАРГА

С.ЭРДЭНЭБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
14 цаг 23 минут.

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Эрдэнэболд: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Ингээд дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хүний эрхийн дэд хорооны 25 оны 9 сарын 30-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Жудагийн Баярмаа, Одсүрэнгийн Номинчимэг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг нар хүрэлцэн ирсэн. Дэд хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсоно. Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Ингээд хэлэлцэх асуудлыг баталлаа.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсоно. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн оролцоо төслийн зөвлөх Э.Эрдэнэхишиг. Эдгээр 3, нэг нь хаана байна вэ? Ийшээгээ суучихгүй юу та.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал ажилласан байгаа. Баасанжаргал гишүүний микрофон, танилцуулгыг микрофоныг нээж, танилцуулгыг сонсьё.

Х.Баасанжаргал: Өнөөдөр Хүний эрхийн дэд хорооны хуралдаа ирсэн гишүүддээ юуны өмнө талархаж байгаагаа илэрхийлье. Би энэ мэдээллийг яагаад зайлшгүй ингэж наана нь өгөх болсон үндэслэл, шалтгаанаа товчхон та бүхэндээ танилцуулъя. Цаашид манай Хүний эрхийн дэд хороо үйл ажиллагаагаа нэлээн тогтмол явуулах, тэгээд цаашаа бодлогын хэмжээнд ажиллахад энэ хөтөлбөр өөрөө нэлээн чухал цаашид guideline болно, хөтөч болно гэж харж байгаа. Тийм учраас яг энэ Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн боловсронгуй болгох ажлын явц ямар явцтай явж байгаа юм бэ, судалгаа нь ямар түвшинд хийгдэж байгаа юм бэ, бид ер нь юун дээр их санал нэгдэх ёстой вэ, манай Хүний эрхийн дэд хороо ямар

амбицтай, ямар зүйлүүд дээр нэлээн ийм бодлогын түвшиндээ санал нэгтэй байх ёстой вэ гэдэг дээрээ нэлээн ярьж, тохирох нэлээн асуудлууд байгаа учраас би яг энэ ажлын явцын талаар та бүхэндээ танилцуулъя.

2 дугаарт та бүхний саналыг зайлшгүй сонсох хэрэгцээ шаардлага байгаа. Бид ер нь хуулийн төсөл бүх юмнууд бүх юм боогдож дууссаны дараа нэг танилцаад л, тэгээд л нэг явдаг шүү дээ. Тэгэхээр энэ хөтөлбөр өөрөө тэгж явж боломгүй зүйл нэлээн дунд нь байгаад байгаа учраас яг нэг явц дундаа та бүхний саналыг авах зорилготой байгаа учраас өнөөдрийн энэ танилцуулгыг хийж байгаа юм.

Тэгээд үндсэндээ танилцуулгадаа оръё. Юуны өмнө хөтөлбөрийн, 2 дугаар хөтөлбөр гэдгийн учир нь энд байгаа манай зарим гишүүдэд мэдээлэл зарим нь мэдээлэл дутуу байгаа байх. Хамгийн анхны хөтөлбөрийг Монгол Улс 2003 онд хамгийн анхны хөтөлбөрөө баталсан 1 дүгээр хөтөлбөр гээд байгаа. Түүний үргэлжлэл болгоод энэ 2 дугаар хөтөлбөр гэдгийг зайлшгүй байх ёстой юм гээд энэ Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө дотор, хөтөлбөр дотор 4 жилийн хөтөлбөр дотор хийгдэх ёстой ажил гэдгээр энэ хөтөлбөр өөрөө орчихсон явж байгаа. Тийм учраас энэ ажлын хэсэг ажиллаад явж байгаа.

Бусад улс орны туршлагыг юуны өмнө бид судлах хэрэгцээ шаардлага гарсан. Учир нь гэвэл мэдээж хүний эрхийн асуудлууд өөрөө олон улсын шинжтэй, глобал шинжтэй, нэлээн ийм үндэстэн дамнасан чухал асуудлууд сүүлийн үед нэлээн улс орны анхаарлын төвд ороод байгаа. Тийм учраас гадаад улсын туршлагыг 1 дүгээрт судлах, 2 дугаарт бусад улс орны зарим нэг зүйлүүд дээр санаа авах олон ийм чухал бүтцийн ч гэдэг юм уу, агуулгын хувьд гээд олон зүйлүүд бидэнд нэлээн сургамж авах зүйлүүд байгаа учраас энэ хэсгийг зориуд та бүхэндээ танилцуулъя гэж бодож байгаа. Нийтдээ дэлхийд Хүний эрхийг хангах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөтэй 140 гаруй улс орон байгаа юм байна. Түүнээс 35 орон 2-оос олон удаа баталсан гэсэн үг, манай улс одоо 2 дахиа батлах гэж байгаа гэсэн үг. 75 улс орон ер нь 1 удаа баталсан ийм байдалтай байгаа.

Австрали улс хамгийн анхны Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг баталсан. Тэгээд ингээд графикаас харвал үндсэндээ улс орнууд 2010 оноос хойш маш идэвхтэй энэ үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр, тухайн үндэсний өөрсдийнх нь онцлогт нийцсэн байдлаар энэ Хүний эрхийн төлөвлөгөөгөө баталж ирсэн нь харагддаг. Тэгээд 2010 оноос хойш ч гэсэндээ 2 дахь удаагаа батлах үйл явц нэлээн эрчимтэй өрнөсөн байгаад байдаг. Тэгээд хөтөлбөрийг ингээд харвал зарим улс орон 8, 5, 4 удаа гээд ингээд баталсан байдаг. Тэгээд 1 удаа баталсан гэдэг дээр Монгол Улс ордог, нийтдээ 40 орчим улс энэ дээр байгаад байгаа юм. Гэхдээ энэ нөгөө хугацааны хувьд интервалуудыг нь харвал улс орнуудын хувьд 1-ээс 2 жилийн интервалтай улс 17 улс байдаг, 3-аас 11 жилийн зайтай гээд улс орнуудын хөтөлбөрөө баталдаг интервал хугацаа нь их харилцан адилгүй байгаад байгаа юм.

Тэгээд эд нарыг нийтэд нь дүн шинжилгээ хийгээд харахлаар юу харагдаж байна гэвэл улс орнууд анх батлахдаа хөтөлбөр өөрөө ерөнхий нийтлэг байдлаар тухайн улсын нийтлэг хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр илүү төлөвлөгөө батлагдаж явж байгаад зарим улс орнууд одоо яаж байна гэвэл илүү сэдэвчилсэн байдлаар дагнах байдлаар баталдаг ийм хэв маяг руугаа орж байгаа юм байна лээ. Ямар орнууд нь тийм байна вэ гэвэл хүний эрхийн асуудал дээр нийтлэг асуудлуудаа шийдчихсэн, ахиц дэвшлээ гаргачихсан гэж үзэж байгаа улс орнууд илүү дагнах байдлаар хөтөлбөрөө батлах ийм зүйл ажиглагдаж байгаа гэсэн үг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас яг энэ Хүний эрхийн төлөвлөгөө, үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө батлах гарын авлага, загварчилсан ийм гарын авлагууд гаргасан байдаг. Зөвлөгөөг нэлээн ийм дэлгэрэнгүй байдлаар гаргасан байдаг. Тэгээд энэ дээр ингээд харахлаар, дараачийнх нь слайд, энэ дээр харахлаар юу харагддаг вэ гэвэл ер нь энэ төлөвлөгөөний хэлбэр, агуулга дээр нэлээн ач холбогдол өгдөг улс орнууд. Яг энэ гарын авлагыг үзэхлээр анх ер нь нэг ийм хүүрнэл хэлбэртэй бол энэ хөтөлбөрийг баталж ирсэн байдаг. Хүүрнэл хэлбэртэй. Сүүл рүүгээ 2012 оноос хойш илүү хүснэгт хэлбэр илүү нэмэгдээд, тэгээд илүү ийм хослох маягтай хөтөлбөрийг баталж ирсэн байгаад байгаа юм. Буцаагаад явуулчих, цааш нь явуулчих. Жишээ нь Гүрж улсын жишээ байна хүснэгтийн хэлбэр гээд. Тэгээд энэ дээр хүснэгтийг нь харвал зорилго, зорилт, индикатор, үйл ажиллагааны төлөвлөгөө, цаг хугацаа гээд ингээд зарим улс орнууд бүүр төсвийг хүртэл давхар баталж ирдэг юм байна лээ. Юуны хувьд жишээ нь Швед улсын хувьд хүснэгт болоод хүүрнэх хоёрыг холимог байдлаар баталж ирж байгаа юм.

Ингээд харахлаар улс орнуудын хувьд агуулгын хувьд харилцан адилгүй зүйлүүдийг тусгаад, үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг юм нь давхар ингэж заавал явдаг зорилго зорилт, дээрээс нь activity буюу үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд давхар авч явдаг. Манай одоогийн байгаа бидний гар дээр ирчхээд байгаа Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирсэн байгаа төсөл үндсэндээ дандаа үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлбэртэй яваад байгаа. Цааш нь явуулаарай, слайдаа цааш нь явуулъя дараагийнх нь. Ингээд энэ дээр улс орнууд ямар, ямар хэчнээн үйл ажиллагааны төлөвлөгөө тусгадаг вэ гээд харахлаар харилцан адилгүй байгаад байгаа юм. Тэгэхдээ энэ дээр нэг ийм сонирхолтой нэг зүйл нь юу вэ гэвэл Финлянд ч гэдэг юм уу хүний эрхийн хувьд нэлээн ахиц дэвшилтэй улс орнуудын хувьд маш системчилсэн байдлаар энэ зүйлүүд нь гардаг үйл ажиллагааных нь төлөвлөгөө нь гардаг. Шри Ланка ч гэдэг юм уу, Шри Ланка гэхэд одоо тэр 971 гээд байгаа нь Шри Ланка улс. Тэгээд ингээд нэг хэт ийм том, өргөн цар хүрээтэй байдлаар үйл ажиллагааны төлөвлөгөө гарах нь нэг талдаа их том асуудлыг хүний эрхийн бүх асуудлаа орхигдуулахгүй ийм шийдвэрлэх сайн талтай ч гэсэн, эргээд нөгөө талаараа хэрэгжихгүй байх магадлал маш өндөр байгаад байгаа юм.

Дараачийнх нь, тэгээд бидэнд нэг тохиолдож байгаа нэг зүйл нь юу вэ гэвэл энэ шалгуур үзүүлэлтүүд. Яг энэ Хүний эрхийн хөтөлбөр дээр байгаа шалгуур үзүүлэлтүүдээ бид шалгуур үзүүлэлттэй хийх юм уу, шалгуур үзүүлэлтгүй хийх юм уу гээд харахлаар сүүлийн үед улс орнууд илүү шалгуур үзүүлэлттэй хийх чиг хандлага давамгайлж байгаа. Би өчигдөр Хууль зүйн байнгын хороон дээр хэлсэн, манай хууль зүйн салбарын ажлын шалгуур үзүүлэлт нь өөрөө нэлээн хангалтгүй байгаад байгаа юм. Бид яг энэ хөтөлбөр боловсруулахтай холбоотой хуулийн салбарынхны энэ ажлын шалгуур үзүүлэлтийг татаж аваад үзэхлээр яг үнэндээ үндсэндээ хүний эрхийг хангахын төлөө жишээ нь цагдаагийн байгууллага, хүний эрхийг хамгаалахын төлөө ажиллаж байгаа прокурорын байгууллагын шалгуур үзүүлэлт гээд ингэхлээр ерөөсөө хүний эрхтэй холбоотой шалгуур үзүүлэлт огт тавигдаагүй байх жишээтэй явж байгаа гэсэн үг.

Байгууллагуудыг тодорхойлсон байдлуудыг харна. Яг хөтөлбөр дээрээ аль, аль байгууллага вэ гэдгээ яг тодорхойлдог юм уу гээд харахлаар нийтдээ 68 хувь нь байгууллагыг тодорхойлсон байдалтай байдаг. Яг байгууллагуудыг яг тодорхой байдлаар тусгасан байдаг. Түүнээс гадна дэмжлэг үзүүлэх олон улсын байгууллагуудыг дурдах, хамтрагч байдлаар дурдах байдлууд нэлээн ажиглагдаж байгаа. Тэгэхдээ бас ийм хүний эрхийн хөгжил төлөвлөгөөнийхөө цар хүрээнээс

нэлээн хамаарч байгаа. Тэгээд хөгжиж байгаа болон буурай улс орны хувьд илүү Олон улсын байгууллагыг илүү хөтөлбөр дээрээ түлхүү тусгадаг ийм байдал байна гэж харж байгаа.

Хорват улсын хувьд ийм жишээ байгаа. Тэгээд нэгэнт та бүхний гар дээр тараагдчихсан байгаа. Хорват улсын хувьд яг нөгөө зорилгоо тавиад, зорилтоо тавиад, шалгуур үзүүлэлтээ тавиад, төсвөө тавиад, төсвөө бүүр нарийн тавьсан байгаад байгаа юм. Яг энэ үйл ажиллагаа дээр хэчнээн төгрөгийн төсөв юм, хэдэн онд зарцуулах юм бэ гээд маш нарийн ийм төлөвлөгөө Хорват улсын хувьд гаргадаг. Тэгэхээр ингээд бид энэ бүхнийг нэлээн харж байгаад нэлээн ийм ахиц дэвшилттэй ийм төлөвлөгөө гарах ёстой болов уу гэж харж байгаа. Тэгээд ер нь улс орнуудынхыг харахлаар хэрэгжих дундаж хугацаагаа 4,5 жил гэж үндсэндээ дундаж хугацаа байгаа.

Манайх болохлоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульдаа захирагдаад 10 жилээр хийх ийм дүр зураг одоогийн байдлаар байгаа. Яах вэ улс орнуудын дундаж хугацаа 4,5 жил, 5 жил байгаа нь үр нөлөөтэй гэдэг ийм дүгнэлтийг улс орнууд хийдэг. Яагаад гэвэл хүний эрхийн нөхцөл байдал өөрөө маш их шинэчлэгдэж байгаа, маш олон сорилт бэрхшээлүүд ирээдүйд тулгамдаж байгаа учраас заавал ийм урт хугацаагаар хийх шаардлагагүй гэдэг ийм зүйл сүүлийн үед нэлээн ажиглагдаж байгаа юм байна лээ. Тэгээд нийт төлөвлөгөөний хугацаанаас гадна төлөвлөгөөнийхөө төлөвлөгөө дотор байгаа үйл ажиллагааныхаа хугацааг нарийн заах гэдэг ийм зүйл сүүлийн үед нэлээн гарч байгаа. Тэгээд Австрали, Австралийн хувьд жишээ нь нийт төлөвлөгөөнийх нь хугацаа нь 10 жил байлаа гэхэд доторх үйл ажиллагааг нь энэ үйл ажиллагаа, энэ зорилтыг 3 жилийн дотор биелүүлнэ, энэ зорилтыг 5 жилийн дотор биелүүлнэ ч гэдэг юм уу ингээд ялгаатай байдлаар хугацаагаа тавьж байгаа ийм жишээнүүд байгаа гэсэн үг.

Дараачийн зүйлүүд байгаа. Герман, Хятад, Австрали гээд улс орнуудын энэ жишээнүүдийг харахлаар маш сонирхолтой зүйлүүд ажиглагддаг. Герман улсын хувьд, ер нь тэгэхдээ ийм юм байна лээ, Герман, Хятад ингээд улс орнуудыг харахлаар хүний эрхийн төлөвлөгөөгөө дотоодын хүний эрхийн нөхцөл байдал дээрээ анхаарахаас гадна олон улсын хүний эрхийн нөхцөл байдал дээрээ анхаарч, аягүй амбицтай төлөвлөгөө гаргадаг болсон байна сүүлийн үед. Жишээ нь Герман феминист гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлэх, жендерийн эрх тэгш байдал дээр илүү анхаарна ч гэдэг юм уу. Ингээд нөгөө ганцхан дотоодын нөхцөл байдал гэлтгүй, гаднын бусад улс орон, глобал хэмжээний хүний эрхийн асуудлууд дээр манай улс ямар оролцоотой байх юм бэ гэдгээ энэ хөтөлбөрөөрөө тодорхойлдог ийм зүйл байгаад байгаа юм.

Тэгээд Хятад бүүр анхаарал татдаг. Энэ Хятадын Хүний эрхийн төлөвлөгөөний бүтэц нь харагдаж байгаа. Хятадын яг хүний эрхийн төлөвлөгөө үндсэндээ их аягүй сайн байсан. Бид Хятадыг нэг арай өөрөөр хардаг шүү дээ, Хятад улсын хувьд. Гэтэл хүний эрхийн хувьд маш их ахиц дэвшил гаргах ийм амбицтай ийм төлөвлөгөө 21-ээс 25 онд хэрэгжүүлэх ийм төлөвлөгөө гаргаж байгаа. Тэгээд энэ дотроо байгаль орчны эрхийн асуудлыг, бүлгийн эрхийн асуудлыг, хүний эрхийн боловсролын асуудлыг, дэлхийн хүний эрхийн засаглалд оролцох гээд энийгээ бүүр тусдаа бие даасан бүлэг болгоод, ийм амбицтай байдлаар төлөвлөгөөгөө улс орнууд гаргаад байгаа юм. Тэгэхээр хүний эрхийн асуудлыг зөвхөн дотоодын асуудал гэж харахгүй, олон улс дахь хүний эрхийн асуудал дээр улс орнууд өөрсдийнхөө амбицыг илэрхийлдэг ийм том стратегийн баримт бичгийн хэмжээнд авч үздэг юм байна гэдгийг бид эндээс харах боломжтой.

Мөн Хятад улсын хувьд миний бас нэг анхаарал татсан юм юу вэ гээд хүний эрхийн боловсрол, судалгаа гэдэг хэсэг дээр нэлээн анхаарал тавьж, нэлээн энэ дээрээ төлөвлөгөөгөө маш нарийн гаргасан байсан. Тэгээд бид хүний эрхийн боловсролыг дандаа ингээд нөгөө жишээ нь юу гэдэг юм амьд явах эрх, хүний өмчтэй байх эрх, шашин шүтэх эрхийн агуулга дотор л боловсролыг оруулаад байдаг болохоос яг боловсролыг бие даасан байдлаар ер нь харж байсан ийм баримт бичиг манай дээр тун ховор байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хүний эрхийн боловсрол өөрөө аягүй чухал юм гэдэг зүйл улс орнуудын бодлогын баримт бичгүүд дээр харагддаг гэсэн үг.

Австрали улсын хувьд нэг зүйл байгаа. Австралийн хувьд юу вэ гэвэл тодорхой бүлгийн эрхийг хангах хүрээнд нэлээн анхаарал хандуулдаг. Австрали хамгийн сүүлд 2012 онд хүний эрхийн төлөвлөгөөгөө батлаад, 12 оноос хойш дандаа дагнасан, мэргэшсэн ийм тухайн дагнасан асуудлаар төлөвлөгөө гаргадаг болчихсон. Тэгээд Австралийн хувьд яах вэ манайх нийтлэг хүний эрхийн асуудлуудаа шийдчихсэн учраас одоо бид яг гэр бүлийн хүчирхийллийн асуудал дээр илүү төлөвлөгөөгөө гаргаж, илүү энэ дээр илүү анхаар ажиллана ч гэдэг юм уу ингээд ийм сэдэвчилсэн байдлаар Австрали төлөвлөгөөгөө гаргадаг болсон байна лээ.

Би яагаад энэ бүгдийг хэлээд байгаа вэ гэвэл манай зарим экспертүүдийн хувьд Монгол улс нийтлэг байдлаар хүний эрхийн асуудал дээр төлөвлөгөө гаргах хэрэгцээ, шаардлага ер нь байгаа юм уу гэдэг асуудлууд хэлэлцүүлгүүд дээр гардаг. Тэгэхээр манайх нийтлэг байдлаар хүний эрхийн асуудал дээр ахиц дэвшил бас айхтар тийм өндөр түвшинд хүрээгүй байгаа учраас нийтлэг ийм байдлаар хүний эрхийн асуудлуудаа анхаарах ёстой юм байна гэдэг ийм зүйлийг бусад улс орны жишээн дээр харахаар байгаа.

Шотланд улсын хувьд илүү тэргүүлэх 8 чиглэлүүдээ тодорхойлоод явчихдаг юм байна лээ. Яг илүү фокуслах асуудлуудаа тодорхойлоод явчихдаг. Энэ дотроо ялангуяа эрүүл мэнд, хүний сайн сайхан байдал, хүрээлэн буй орчныг сайжруулах ч гэдэг юм уу ингээд фокуслах ёстой 8 асуудлууд гээд тодорхойлчихдог. Шотландын хувьд хүн өөрийнхөө human dignity буюу хүний эрхэм чанараа хадгалж амьдрах тэр бүх нөхцөлийг манай улсын гол vision алсын хараа болгоно гээд тодорхойлсон байдаг юм байна лээ. Тэгээд бид энэ бусад улс орнуудын жишээг харахлаар юу ажиглагдаж байна вэ гэвэл тухайн улс орон хүний эрхийн асуудал дээрээ ямар ахиц дэвшил гаргах вэ, ямар өөрчлөлт авчрах вэ гэдэг дээрээ илүү гол анхаарлаа төвлөрүүлдэг юм байна гэдэг нь ажиглагдана.

Дараачийнх нь. Ерөнхийдөө нэг ийм хүний эрхийн хөтөлбөрийг боловсруулах ийм замын зураглал гэдгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас жишиг зургийг гаргаад өгчихсөн байдаг. Энэ гарахгүй байна уу, энэний дараачийнх нь юун дээр нь үү, ингээд шууд орчхоод байна уу? Та бүхний цаасан дээр юу яачихсан байгаа яг энэroud map-ыг дэлгэрэнгүй тавьчихсан байгаа. Тэгээд яг энэroud map-ын дагуу бид явах ёстой юм байна гэдгийг нэлээн харсан. Тэгэхгүй бол бид аягүй олон зүйлийг энэ дунд орхигдуулаад, ер нь аливаа хөтөлбөр батлахдаа нөгөө батлах нь аягүй чухал гэдэг дээр илүү ач холбогдол өгөөд, яг нөгөө хэрэгжилтийн явцад гарах хүндрэл, бэрхшээлүүдээ яаж шийдэх вэ, хэрэгжилтийн явцад ямар эрсдэлүүд үүсэж болох вэ, тэрийг яаж даван туулах вэ гэдэг төлөвлөгөөнүүд ерөөсөө бид гаргадаггүй, олон шат дамжлагыг бид жаахан алгасаад явчихдаг тийм сул тал манай улсын төлөвлөгөөнүүдээр ажиглагдсан. Тийм учраас манай ажлын хэсэг энэ удаа

арай нэг ийм өөр арга барилаар ажиллаж байгаа гэдгээ танилцуулах гээд байгаа гэсэн үг.

Дараагийн 2 дахь хэсэг, 23-аас 24 оны хооронд ямар ажлууд хийгдэв гэдгийг би товчхон мэдээлэл өгөөд, үндсэндээ миний мэдээлэл дуусна. Энэ дээр нэг ийм юм байгаа. Бид нэг юман дээр манай Хүний эрхийн дэд хорооных эхлээд энэ Хүний эрхийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг анх Хүний эрхийн Үндэсний Комисс дээр байгуулаад, яг эдгээр хүмүүсийн бүрэлдэхүүнтэй 23 онд хамгийн анхны төсөл нь гарсан байдаг юм. Тэгээд яг энэ хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байгуулсан ажлын хэсэг 2 жил хэрээтэй ажиллаад, төслөө өнгөрсөн жил Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд, тэгээд өнгөрсөн жил Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсний дагуу Хууль зүйн дотоод хэргийн яамныхан Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөл дээр ажиллаад, ингээд 7 зорилго, 33 зорилт, 132 үйл ажиллагаатай төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулаад, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн ийм байдалтай байгаа гэсэн үг. Одоогийн байдлаар гэсэн үг.

Тэгээд энэ хэсэгт яг ингээд нэгэнт Хууль зүйн яамны ажиллачихсан төлөвлөгөө төсөл байгаа учраас манай ажлын хэсэг энэ хэсгийг нь сайжруулаад, илүү нөгөө зорилттой, шалгуур үзүүлэлттэй илүү зөв төлөвлөгөө болгох тал дээр нь илүү бид ажиллаж байгаа гэсэн үг. Тэгэхээр үндсэн яах вэ рам, үндсэн гол зүйлийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн Үндэсний Комисс дээр байгаа багийнхан гаргаад, ажиллачихсан гэсэн үг. Одоогийн байдлаар манай энэ хөтөлбөрийг сайжруулах баг дээр үндсэндээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Оролцоо төслийнхөн, Канадын Канад сангийнхан, Канад сангийн Мерит гээд энэ 2 төслийнхөн бидэнд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагын оролцоо төслийнхөн бол аль хэсэг дээр нь илүү анхаарч ажиллаж байгаа вэ гэвэл Монгол Улс энэ хүний эрхийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах ямар нэгэн ийм үйл явцдаа иргэдийнхээ оролцоог хангах тал дээр жаахан учир дутагдалтай байна. Тэгэхээр иргэдийн оролцоог хангасан ийм өргөн хэмжээний хэлэлцүүлэг өрнүүлээч. Энэ хэсэг дээр нь Нэгдсэн Үндэстний Байгууллага дэмжээд, оролцоод хамтраад явъя гэж байгаа юм.

Тэгээд та бүхэнд тараагаад өгчихсөн байгаа төлөвлөгөөний 2 дахь төлөвлөгөө байгаа. Нэлээн ийм деталь төлөвлөгөө байгаа. Энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагаас яг энэ оролцооны төлөвлөгөөг бидэнд санал болгож байгаа, бид хамтраад боловсруулсан гэсэн үг. Тэгээд манай Хүний эрхийн дэд хорооны гишүүд энэ Оролцоо төслийнхөнтэй хамтраад яг энэ хөтөлбөрийн явцад олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаанд хэрвээ та бүхэн маань оролцоно гэвэл нээлттэй. Аль дуртай үйл ажиллагаандаа оролцоод Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтраад ажиллаарай, ажиллах тэр зүйлд чинь дэмжлэг болоод ажиллая гэж хэлж байгаа гэсэн үг. Тэгэхээр та хэд маань төлөвлөгөөтэй нарийвчлан танилцаад, ажлын албандаа хариуцуулж өгөөд аль, аль хэсэг дээр нь, аль, аль бүлэг дээр нь, аль, аль сэдэв дээр нь та бүхэн ажиллах хүсэлтэй байна гэдгээ хэлбэл зохион байгуулалтыг бид хэд хийгээд, манай ажлын албаныхан хийгээд, гишүүдээ бид оролцуулаад ажиллая гэж байгаа юм.

Юуныхан болохоор Мерит төслийнхөн болохоор ямар учиртай юм гэвэл үр дүнд суурилсан удирдлагын арга зүй буюу ер нь энэ төлөвлөгөө боловсруулах арга зүйгээ нэг жоохон өөрчлөх, ялангуяа шалгуур үзүүлэлт хэмжих нэгж сайтай ингэж төлөвлөгөө боловсруулах энэ хэсэг дээр нь илүү арга зүйн дэмжлэгийг Меритийнхэн үзүүлж байгаа гээд манайхан ойлгочхоорой. Тэгээд манай 2 төслийнхөн сая энэ зун бид нэлээн ажиллаж байгаад, ингээд бид хэд одоогийн байдлаар юу гаргачхаад

байна вэ гэвэл хамгийн, юун дээрээ тавьчих дараагийнх дээрээ явчих, логик загвар гэсэн хэсэг дээрээ, ингээд ажлын хэсгүүд ажилласан мэдээллүүд явж байгаа. Энэний дараачийнх дээр, дахиад дараачийнх дээр.

Энэ хэсэг дээр би та бүхнийхээ саналыг авах гээд байгаа юм. Энэ юу вэ гэвэл яг одоогийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яамны ажиллаад өгчихсөн байгаа төсөл ямар байгаа вэ гэвэл бид ер нь нэг ийм мөрөөдлийн жагсаалт, ер нь хиймээр байгаа бүх юмаа бид тэн дээр биччихсэн. Бүх хүний эрхийн хувьд ахиц дэвшил гаргамаар байгаа бүх зүйлүүдээ ерөнхийдөө биччихсэн, нэлээн өргөн хүрээг хамарчихсан ийм төсөл байгаа. Манай ажлын хэсгийнхний хувьд энэ дээр ажиллаад юуг харсан бэ гэвэл бид тодорхой хэмжээний хийж чадах хүрээ хязгаараа нэлээн сайн гаргах ёстой юм байна. Тэгэхгүй бол Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг бүгдийг нь сайжруулна гээд бариад орчихдог, нөгөө хэрэгжилтийнхээ явцад нэлээн асуудал үүсэх нэлээн асуудлууд байгаа учраас түүн дээр бид нэлээн сайн харах ёстой юм байна, нэлээн арга зүйтэй ажиллах ёстой юм байна гэдэг ийм дүгнэлтэд хүрээд, одоогийн байдлаар хүрээгээ ингэж гаргачхаад байгаа юм. Энэ чухам манай гишүүдэд ямар байх нь вэ гэдэг дээр нэлээн та бүхэнтэй тухайлан саналыг чинь авна гэж үзэж байгаа.

Тэгээд Монгол Улсад ялангуяа зорилтот бүлгийн иргэдийн эрхээ эдлэх боломж, оролцоо, чадавхыг сайжруулах гэдэг бол бидний хамгийн гол хүрээ гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл иргэд илүү imparaad буюу иргэд илүү эрх мэдэлжих тэр тал руу нь энэ хөтөлбөр өөрөө явах ёстой. Тэрнээс биш төрөөс хүний эрхийг өгч байгаа юм шиг ийм дүр зурагтай, ийм байр суурьтайгаар энэ хөтөлбөр ерөөсөө боловсруулахгүй. Иргэд өөрсдөө өөрсдийнхөө эрхийг хамгаалах, өөрсдийнх нь эрхийн асуудал дээр илүү иргэдэд өөрсдөд нь эрх мэдэл өгсөн ийм арга зүйтэй явна гэдэг ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Тэгээд энэнийхээ хүрээнд эрх зүйн орчиндоо бүтцийнхээ хувьд хүний эрхийн боловсрол дээр, тэр дундаа бодлого боловсруулах, хууль сахиулах байгууллага дээр ямар үр дүн гаргахын төлөө ажиллах вэ гэдэг ийм хүрээг гаргасан гэсэн үг. Дараачийнх нь.

Цаашид хийгдэх ажил дээр нэг ийм зүйл байгаа. Нийтдээ 64 ажлын төлөвлөгөө гаргачихсан байгаа. Энэ дээр нэг агуулгын ажлын төлөвлөгөө дээр 29 ажил байгаа. Бид хэд одоо 30 хувьтай явж байгаа. Яг нөгөө сурталчилгаа, нөлөөллийн ажил, судалгаа шинжилгээний ажлууд гээд ингээд 25 ажил, 10 ажил төлөвлөчихсөн байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн оролцох сонирхол байвал сонирхлоо илэрхийлээрэй гэсэн үг. Дараачийнх нь, дахиад дараачийнх нь явчих.

Бид чуулган дээр нэг ийм хууль орж ирнэ. Манай Алтангэрэл сайн мэдэж байгаа, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өргөн барьчихсан байгаа хуулийн төсөл дээр Хүний эрх, эрх чөлөөг хангах зорилтот хөтөлбөрийг бид нэг хөтөлбөр болгож оруулах ийм хуулийн төсөл өргөн баригдчихсан. Энэ дээр манай гишүүдийн дэмжлэг хэрэгтэй байгаа. Тэгээд ажлын төлөвлөгөөний хувьд бид цаашид 12 сарын 10-нд гэхэд ядаж хүний эрхийн чуулганаар Хүний эрхийн хөтөлбөрийг дэмжинэ. Хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн байхаар ингэж ажлын төлөвлөгөө гаргасан байгаа шүү гэдгийг гишүүддээ танилцуулъя. Ингээд боллоо, даргаа.

С.Эрдэнэболд: Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай энэ асуудал их чухал байгаа. Тэгээд Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн танилцуулга хийж дууслаа. Манай Байнгын хорооны гишүүдийн зүгээс, дэд хорооны гишүүдийн зүгээс танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Үг тусдаа байгаа, асуулт тусдаа байгаа. Асуулт асуух гишүүд товчлуур дээрээ

дарна. Асуулт асуух гишүүн, дэлгэц дээр харагдах хэрэгтэй байгаад байна. Хяналт харагдахгүй байна. Одоогоор Соронзонболд гишүүн, Алтангэрэл гишүүн 2 кноп дарсан байна. Яах вэ дахиад асуулттай гишүүн байвал кноп дараарай. Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Соронзонболд гишүүний, байж байгаарай ирцээрээ Алтангэрэл гишүүн дээшээ гарчихлаа. Тэгэхээр Алтангэрэл. Соронзонболд гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Баасанжаргал гишүүн энэ ажлыг авч яваад, санаачлаад ингээд хийж байгаа нь мундаг байна. Энэ чинь амаргүй ажил юм билээ. Бид энэ Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр ер нь Монгол Улсад хэрэгжиж дуусаад, тэгээд хэрэгжилтийн хэрэгжилт дээр нь ер нь бид хараад ингээд ер нь юу хийж бүтээсэн юм, ямар амжилт олсон юм, юун дээр алдсан юм гээд ингэнгүүт үргэлжлүүлэх шаардлагатай гээд үзсэн. Тэгээд бүүр яаман дээр баг гараад, ажиллаад, Хүний эрхийн Үндэсний Комисстой яриад ингээд хийж байсан амаргүй ажил юм байна лээ. Тэгээд ямар баг бүрэлдэхүүнтэйгээр хийв? Юун дээрээс Хууль зүй, дотоод хэргийн яам дээрээс ер нь боловсруулж байсан төслөөс яг гол ялгагдах ялгаанууд, хүрээ нь өргөжив үү, илүү хумигдав уу? Дүгнэх шалгуур үзүүлэлтийн хувьд ямар нэг байдлаар өөрчлөлт орсон уу гэсэн ийм асуулт байна?

С.Эрдэнэболд: Баасанжаргал гишүүн хариулъя.

Х.Баасанжаргал: Хүрээ хумигдав уу, хүрээ өргөжив үү гэдэг дээр яг одоохондоо хариулахад эрт байгаа. Яагаад гэвэл бид яг энэ нөгөө одоо би саяын танилцуулсан нөгөө логик хүрээ гээд, логик frame гээд байгаа яг түүн дээрээ бид тохирч байж, бид яг 5 жил, 10 жилдээ юу хийж чадах юм бэ гэдэг дээрээ тохирч байж, бидний тэр нөгөө хөтөлбөрийн хүрээ гарах юм байна лээ. Одоогийн байдлаар Хууль зүйн яамны боловсруулаад ирүүлчихсэн байгаа хөтөлбөр бол ер нь хүний эрхийн хувьд бид ямар баймаар байгаа юм бэ гэдэг бүх зүйлүүдээ үндсэндээ маш өргөн хүрээтэй багтаачихсан гэсэн үг. Маш өргөн хүрээтэй. 2003 оны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхээр тэн дээр нэг том асуудал нь, асуудал гарсан нь юу вэ гэвэл нөгөө хэрэгжих шалгуур үзүүлэлт, механизмаа оновчтой тодорхойлоогүй учраас үндсэндээ 2003 оны хөтөлбөрийн зарим хэсэг үндсэндээ хэрэгжиж чадаагүй гэдэг дүгнэлт гардаг байхгүй юу. Тэгэхээр 1 дүгээрт энэ алдааг бид давтахгүйн тулд хүрээгээ маш сайн тодорхой гаргаж ирье гэж байгаа юм.

2 дугаарт механизмаа маш оновчтой тодорхойлохгүй бол жишээ нь нөгөө та хэд санаж байгаа бол Авлигатай тэмцэх газрын төлөвлөгөө, Шүүхийн хөгжлийн төлөвлөгөө гээд хамгийн сүүлд бидний баталсан нэг ийм 2 төлөвлөгөө байгаад байгаа юм. Түүн дээр харахаар яг нөгөө хэрэгжүүлэх байгууллага нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Авлигатай тэмцэх газар гээд байгаа боловч үндсэндээ авлигатай тэмцэх, энэ шүүх эрх мэдлийн асуудал, хүний эрхийн асуудал чинь уг нь нийт салбарын асуудал шүү дээ. Эрүүл мэндийн яам ч ажиллаж байх ёстой тийм ээ. Тэгэхээр тэр механизмуудаа аягүй зөв тодорхойлох ёстой юм байна лээ. Тэгэхээр эд дээр бид нэлээн ажиллах хэрэгцээ шаардлага байгаа учраас нөгөө логик хүрээ буюу бидний яг хүний эрхийнхээ хүрээг бид яг ойрын чухал асуудлуудаа яг ямар хүрээгээр татах вэ гэдэг нь аягүй чухал юм байна лээ.

3 дугаарт нэг зүйл байна лээ. Хүний эрхийн Үндэсний Комисс болоод Хууль зүйн яам хоёр хоёулаа энэ хөтөлбөрийн төслөө боловсруулахдаа яг Монгол Улс дахь өнөөгийн хүний эрхийн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийгээгүй оруулаад ирсэн. Тэгэхээр нөхцөл байдлын дүн шинжилгээг бид дахиж заавал хийх хэрэгтэй болж байгаа байхгүй юу. Тайлбараа болохоор манайхан болохоор юу гэж хэлээд

байна вэ гэхээр жил болгон хүний эрхийн тайлан гарч байгаа, илтгэл гарч байгаа, UPR-н тайлан гарч байгаа, Нэгдсэн Үндэстний Байгууллагад бид олон улсын гэрээний хэрэгжилтээ өгч байгаа учраас хүний эрхийн нөхцөл байдлыг заавал тэгж тусад нь дүн шинжилгээ хийгээд хийгээд байх шаардлагагүй гэдэг тийм тайлбарыг өгсөн юм.

Гэхдээ юуг харахлаар бид нөгөө шалгуур үзүүлэлтээ гаргахаар одоо бид ямар түвшинд байгаа юм, дараа нь ямар түвшинд хүрэх юм бэ гэхлээр нөхцөл байдлаа заавал хийх хэрэгтэй болж таараад байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд нөгөө нэг ийм нөхөж хийгдэх судалгаанууд энэ тэр юмнууд нэлээн гарч ирээд байгаа гэсэн үг явц.

С.Эрдэнэболд: Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Баасанжаргал гишүүний ерөнхий гаргасан төлөвлөгөө ингээд юутай харахад нэлээн олон улсын туршлага судлаад, улс орнууд яаж хийж байгаа талаар маш сайхан судалгааны ажлууд хийгдсэн байна. Тэгээд яах вэ анхны нөгөө 1 дүгээр хөтөлбөртэй ингээд харьцуулаад үзэхээр хамгийн чухал тийм ээ, яаралтай засаж шийдвэрлэх ёстой асуудлууд нь мэдээж илүү богино хугацаандаа ажиллах ёстой гээд чиглэлээ юугаа тавьсан байх гэж бодож байгаа юм, ач холбогдлын зэргээ тийм ээ. Дараагаар нь болохоор энэ зорилтот бүлэг гэж яриад байна шүү дээ. Тэгэхээр зорилтот бүлэг гэдэг дээр болохоор яг нийгмийн тодорхой хэсгийг яриад байна уу, эсвэл ерөнхийд нь хүний эрх гээд түрүүний бусад улсуудын юуг харахаар чинь аягүй их general маш олон асуудал байна шүү дээ хүрээнүүд нь. Тэгэхээр ямар байдлаар тавьж байна вэ гэдэг нэг ийм тодруулах асуулт байна?

С.Эрдэнэболд: Баасанжаргал гишүүн хариулт өгье.

Х.Баасанжаргал: Зорилтот бүлэг гэдэг дээр ийм юм байдаг юм байна манайх. Хууль тогтоомжууд дээр зорилтот бүлэг гээд ингээд хэд хэдэн янзаар тодорхойлдог. Гэхдээ тухайн салбарынхаа хууль тогтоомжоос хамаараад зорилтот бүлгээ харилцан адилгүй тодорхойлдог юм байна. Бид хэд нөгөө өнгөрсөн хугацаанд хийгдсэн 20 хэдэн удаагийн Хүний эрхийн Үндэсний Комиссын жилд жил болгон хийдэг илтгэл дээр дүн шинжилгээ хийгээд үзэхлээр хамгийн анхаарах ёстой хүний эрхийнхээ хувьд хамгийн анхаарах ёстой бүлэг 1 дүгээрт хүүхэд гарч ирсэн. Ямагт дандаа хүүхдийн асуудал, хүүхдийн эрхийн асуудал дээр манай улс дандаа маш олон ийм асуудлууд дандаа дагуулдаг гэдэг нь зорилтот бүлгүүд дотроос 1 дүгээрт хүүхдийн эрхийн асуудал гарч ирсэн. Асуудлууд дотроос 1 дүгээрт гэр бүлийн хүчирхийллийн асуудал, жендерт суурилсан хүчирхийллийн асуудал хоёр яг 1 дүгээрт гарч ирсэн. Ингээд асуудлаар нь эрэмбэлбэл харилцан харилцаа адилгүй, бүлгээр нь эрэмбэлбэл бас харилцан адилгүй ийм бүлгүүд гарч ирдэг. Тэгэхээр бид нөгөө хүрээн дээрээ бид алин дээр илүү төвлөрөх вэ гэдэг зүйл байгаад байгаа юм.

3 дугаарт юу вэ гэвэл нийтлэг тулгамдаж байгаа асуудал нь юу вэ гэсэн чинь хүний эрхийн боловсрол гарч ирсэн. Хүний эрхийн боловсрол маш юутай, хүний эрхийн боловсролын асуудлыг системтэйгээр ерөөсөө харахгүй байна 1 дүгээрт. 2 дугаарт тэр дундаа хууль, хүчний байгууллага, улс төр гээд шийдвэр гаргагчдын түвшин дэх хүний эрхийн боловсролын асуудал дээр бас ийм анхаарах ёстой юм байна гэдэг ийм зүйл нэлээн гарч ирдэг. Ялангуяа цагдаагийн алба хаагч гэдэг юм уу, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан ч гэдэг юм уу ингээд нэг ийм тодорхой хэмжээний эрх мэдэл бүхий субъектүүдийн хүний эрхийн боловсролын асуудал дээр анхаарах ёстой гэдэг ийм асуудлууд гарч ирж байгаа гэсэн үг.

С.Эрдэнэболд: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөртэй холбогдуулж хэлэгдсэн, яригдсан мэдээлэлтэй холбогдуулж үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. 1 хүн дарсан байна. Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Бид энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Ингээд 2 үндсэн зүйл дээр би яг энэ хөтөлбөртэй холбогдуулж юм хэлмээр байгаа юм. Өмнө нь урьд урьдын парламентын гишүүдэд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргадаг хүний эрхийн илтгэл, тайланг хэлэлцүүлээд энэ өөрөө нийгмийн их том хэлэлцүүлгийн сэдэв болж явдаг байлаа. Энэ эрүүгийн процесс ажиллагаа яаж явагдаж байгаа юм, бусад чиглэлийн энэ хүний эрхийн төлөв байдал ер нь ямар байгаа юм, сурч боловсрохтой холбоотой, хөдөлмөрлөхтэй холбоотой гээд, ингээд бизнесийн эрх чөлөөтэй холбоотой гээд. Тэгээд харамсалтай нь сүүлийн жилүүдэд энэ маш их бүдгэрсэн. Нэг ийм байх ёстой байгууллагын үйл ажиллагааг нэг ингээд сонсоод өнгөрөөдөг гэсэн шиг ийм байдалтай болсон. Ач холбогдол өгч, арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээ больсон. Харин тодотгож хэлэхэд энэ 126 гишүүнтэй шинэ парламент үүссэнээс, бий болсноос хойш энд нэлээн ач холбогдол өгдөг, сонсдог ийм байгаа.

Дээрээс нь өнөөдрийн энэ хэлэлцүүлж байгаа төсөл бол би Баасанжаргал гишүүн өөрөө олон жил энэ хүний эрхийн чиглэлээр ажилласан, судалгаа хийсэн, туршлага хуримтлуулсны хувьд нэлээн хүч анхаарал зарж хийчихье гэж бодож байгаа. Бид өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа, төсөв хэлэлцэхээр Байнгын хороо Их Хурлын чуулганаараа дүүрэн суугаад л кнопоо дарж байгаад л, тэгээд л ямар нэгэн юм олж хэлэх гээд ингээд л өдөр, шөнөгүй суудаг шигээ энэ Хүний эрхийн үндэсний хөтөлбөр, ер нь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэж байхад бид энэ улс орны ардчиллын хамгийн амин чухал зүйл болсон Үндсэн хуулийн маань амин сүнс оршсон чухал асуудлыг ярьж байна гэдгээ санаж, их ач холбогдол өгч, энэхүү хөтөлбөрөө цаашдаа энэ боловсруулж байгаа үйл явц дээр нь бид дэмжлэг тусалцаа үзүүлж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, батлах нь өнөөгийн Улсын Их Хурлын хуулиар хүлээсэн нэг чухал үүргийн нэг гэж гишүүддээ сануулж хэлье. Баярлалаа.

С.Эрдэнэболд: Би хэдэн үг хэлье гэж бодож байна. Ерөнхийдөө Баасанжаргал гишүүний ахалж байгаа энэ ажлын хэсэг нэлээн нухацтай сайн ажиллалаа гэж харж байгаа. Мөн манай Байнгын хорооны Дэд хорооны гишүүн Хууль зүйн сайдаар ажиллаж байсан Оюунсайханы Алтангэрэл сайд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байхдаа энэ асуудал дээр онцгой анхаарч, энэ асуудлыг Засгийн газраас оруулж ирж тийм ээ, энэ төсөл 282 зүйл, заалттай төслийг Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран ажилласан төслөө бас манай Байнгын хороонд ирүүлж, ингээд энэ процесс маань явж байгаа.

Тэгэхээр энэ үндэсний 2 дугаар хөтөлбөр 22 жилийн өмнө батлагдсан 1 дүгээр хөтөлбөрөөс юугаараа ялгаатай юм. 2 дугаарт одоо энэ нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, хүмүүсийн соёлын хандлага энэ бүх зүйл яаж өөрчлөгдөв. 20-иод жилийн өмнө байсан тухайн нөхцөл байдал одоо энэ шинжлэх ухаан, технологи, амьдралын хэв маягаас үүдэлтэйгээр яаж өөрчлөгдөв гэсэн олон, олон зүйлүүд байгаа. Хүний эрхийн дэд хорооны зүгээс бол 24 оны 10 сарын 22-ноос хойш сар тутам сар болгоны одоо 2 дахь долоо хоногийн Лхагва гаргийн 10

цагаас хүний эрхийн форумын байгууллагуудтай уулзаж, сар болгоны тогтмол уулзалтуудыг хийж явсан байгаа. Ингээд өөрөөр хэлбэл нөгөө саяын Алтангэрэл сайдын, гишүүний хэлдэгчлэн тунхгийн шинж чанартай гэхээсээ илүүтэйгээр яг одоо бодитойгоор энэ үйл ажиллагаа нь амьдрал дээр зохицуулалт болж хүрдэг байх чиглэл рүү явж байгаа.

Тийм учраас Баасанжаргал гишүүний энэ танилцуулж байгаа, мөн ажлын хэсгээс танилцуулж байгаа энэ Хүний эрхийн үндэсний 2 дугаар хөтөлбөр бол зөвхөн хөтөлбөр батлагдаад зогсохгүй, цаашлаад маш олон хуулиудад зохицуулалтуудыг нь шинэлэг болон дэвшилттэй зүйлүүд орно гэж харж байгаа. Бид бол өмнө нь хэвшмэл ойлголтоор хүний эрхийн асуудал бол зөвхөн хууль, шүүхийн байгууллагатай холбоотой л асуудал гэж бодож байсан бол энэ бол тусад нь гаргаад тавьдаг нэг эд, эрхтэн биш, энэ бол нийгмийн бүхий л салбар хүрээ, шийдвэр гаргалтын бүхий л стандартад байх ёстой зүйл гэж бол харж байгаа нь сайн зүйл.

2 дугаарт сая өнгөрсөн 2 сард жишээлбэл утааны сонсгол гээд явлаа гэхэд хүний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал ч гэдэг юм уу, хүний эрхийн асуудлыг нэлээн өргөн хүрээтэйгээр авч үзэж байгаа ийм зүйлүүд бол байгаа. Ингээд ямар ч байсан дэд хорооны зүгээс танилцуулгыг сонслоо. Цаашлаад Баасанжаргал гишүүн болон ажлын хэсгийнхэнд амжилт хүсэж байна. Ямар ч байсан энэ хөтөлбөр энэ намрын чуулганы хүрээнд бол хэлэлцэх асуудлын хүрээнд ороод, батлагдаад, цаашлаад бодит амьдрал дээр үйлчлэл үзүүлээд явах нь их зөв байна гэж харж байна. Тэгээд ажлын хэсгийг ахалж байгаа Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн болон бусад хүмүүст ажлын хэсгийн гишүүддээ талархал илэрхийлье. Цаашдынх нь энэ хөтөлбөр батлуулах ажилд нь амжилт хүсье.

Ажлын хэсгийн мэдээлэлтэй холбогдуулж гишүүд үг, асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Улсын Их Хурлын даргын 24 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг үүгээр сонсож дууслаа.

15.00 цаг

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Их Хурлын гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА